



Аудитын код: САГ-2017/02/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан

Утас: 261628 Цахим хаяг: javkhlang@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн ОРЛОГО ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ талаарх тайлбар, тодруулга	6
2.7	Шилэн дансны мэдээлэл	6
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Батлагдсан төсвийн талаар	7
2.9.2	Өр төлбөр дансны талаар	7
2.9.3	Бараа материалын талаар.....	7
2.9.4	Худалдан авалтын талаар	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	төсвийн хэтрэлтийн талаар.....	11
3.2	өр төлбөр.....	12
3.3	бараа материал	13
3.4	худалдан авалтын талаар.....	14
3.5	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
3.6	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
3.7	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
3.8	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
3.9	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19

1 Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 760
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайланг хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 4 дүгээр

сарын 05-наас 2017 оны 04 дүгээр сарын 21-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан хэрэгжүүлэв.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр тг/189 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын эрхэм зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр бүтээлтэй зохион байгуулж, Ерөнхийлөгчийг үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд цаг үеэ олсон, алсыг харсан, мэргэшсэн зөвлөгөө үйлчилгээгээр хангаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлийн хөтөч байхад оршино.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 152 дугаар зарлигаар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрэм”-ийг баталсан байна. Тус дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий төрийн байгууллага мөн” гэж тус байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлэв.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 3 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 3 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан

түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон ахлах аудитор гүйцэтгэлээ.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлж буй ажилтнуудын үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

2.6 Төсвийн орлого зарлагын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг яамны Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар хянуулж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжигдсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 3,769.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, 3,618.5 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 150.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Ерөнхийлөгчийн Тамгын газар, Ерөнхийлөгчийн төсвийн Шилэн данстай холбоотой Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (*Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр*), тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (*Тухай бүр*), цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг (*Тухай бүр*) <http://www.shilendans.gov.mn/org/449>, <http://www.shilendans.gov.mn/search?searchtext=Ерөнхийлөгчийн+төсөв> веб хуудсуудад байршуулсан байна.

Тухайлбал Ерөнхийлөгчийн Тамгын газар тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 орлогын, 13 зарлагын мөнгөн гүйлгээг, Ерөнхийлөгчийн төсвийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 орлогын, 25 зарлагын мөнгөн гүйлгээг тус тус Шилэн дансанд толилуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх төлөвлөгөөгөөр төлөвлөлтийн шатанд 4 /авлага, өр төлбөр, бараа материал, үндсэн хөрөнгө/ дансанд эрсдэл байж болзошгүй гэж тогтоосны дагуу нарийвчилсан сорилын аргаар тулган баталгаажуулах, ажиглах, харьцуулах зэрэг сорилыг гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 9, тайлагналын үе шатыг 7 ажилбараар тус тус гүйцэтгэв.

Мөн Ерөнхийлөгчийн Тамгын газраас авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, нотлох баримтуудыг тусгайлан ажлын баримтад хавсаргав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Батлагдсан төсвийн талаар

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3,769.2.3 сая төгрөг батлагдсанаас 3,618.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарч зардлын бүлгийн дүнгээр хэтрүүлээгүй боловч бичиг хэргийн зардлыг 2.7 сая, тээвэр шатахууны зардлыг 0.9 сая, шуудан холбооны зардлыг 0.7 сая, багаж техник хэрэгслийн зардлыг 0.4 сая, зочин төлөөлөгч хүлээж авах зардлыг 13.4 сая төгрөгөөр зэрэг нийт 18.1 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалтыг баримталж ажиллах

2.9.2 Өр төлбөр дансны талаар

Төрийн шагнал, одон медалийн төсөвт санхүүжилт дутагдсанаар Зоос гоёл ХК-д 10.5 сая төгрөгийн өр төлбөр үүссэн нь Төсвийн тухай хуулийн 6.8.4-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6.8.4 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2.9.3 Бараа материалын талаар

ЕТГ нь тайлант онд 10.6 сая төгрөгийн бичиг хэргийн бараа материалыг бараа материалын тайлангаар дамжуулалгүй шууд зардалд тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21-т заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2.9.4 Худалдан авалтын талаар

“Ашид нэхмэл” ХХК-д ноосон даавууны үнэ 24.8 сая, “Киокаут” ХХК-д одонгийн хайрцагны үнэ 10.0 сая, АСЕМ-ын үйл ажиллагаанд хэрэглэх модон замын үнэнд 10.0

сая төгрөг зэрэг нийт 44.8 сая төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд худалдаж авсан нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын явцад:

- Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж буй Сангийн яамны “Э-тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй,
- Төрийн сангийн газраас ирүүлсэн ТЕЗ болон Сангийн яам хоорондын тооцоо нийлсэн баримтад хөрөнгийн санхүүжилт, зардлын гүйлгээг тусгаагүй,
- Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн “Э-тайлан” програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан байна.

Эдгээр нь ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар “БДО аудит” ХХК-ний Иргэдийн оролцоо төслийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг авч үзнэ.

Мөн ЗГСНТ-гийн аудитад ТЕЗ-ын төсвийн гүйцэтгэлд төсөвлөгдөөгүй төслийн дүнг хэрхэн нэгтгэх, эсэх талаар Сангийн яамтай харилцан санал солилцох шаардлагатай гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Ерөнхийлөгчийн Тамгын газрын төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 84.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллав.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Ерөнхийлөгчийн Тамгын газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2016 оны 08 сарын 28-ны өдрийн тг/410 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна. /Загвар 9, албан бичиг/

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Аудитын төлөвлөлтийн шат болон гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг 2016 оны жилийн эцсийн тайланд толилуулсан 4,533.9 сая төгрөгийн нийт зардлын 2 хувиар тооцож 90.7 сая төгрөгөөр тогтоов.

Төлөвлөлтийн явцад шинж чанарын болон орчин нөхцөлийн хувьд материаллаг алдаа илэрсэнгүй.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бид Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 ТӨСВИЙН ХЭТРЭЛТИЙН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3,769.2.3 сая төгрөг батлагдсанаас 3,618.5 сая төгрөгийн гүйцэтгэл гарч зардлын бүлгийн дүнгээр хэтрүүлээгүй боловч бичиг хэргийн зардлыг 2.7 сая, тээвэр шатахууны зардлыг 0.9 сая, шуудан холбооны зардлыг 0.7 сая, багаж техник хэрэгслийн зардлыг 0.4 сая, зочин төлөөлөгч хүлээж авах зардлыг 13.4 сая төгрөгөөр зэрэг нийт 18.1 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

-Төсвийн тухай хуулийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

-Энэхүү зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 ӨР ТӨЛБӨР	Тэргүүлэх ач холбогдол №1
---------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

Төрийн шагнал, одон медалийн төсөвт санхүүжилт дутагдсанаар Зоос гоёл ХК-д 10.5 сая төгрөгийн өр төлбөр үүссэн нь Төсвийн тухай хуулийн 6.8.4-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

-Төсвийн тухай хуулийн 6.8.4-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

-Энэхүү зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.3 БАРАА МАТЕРИАЛ	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>ҮАГ-ын ажиглалт</u> ЕТГ нь тайлант онд 10.6 сая төгрөгийн бичиг хэргийн бараа материалыг бараа материалын тайлангаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21-т заасантай нийцэхгүй байна. <u>Эрсдэлүүд</u> Бараа материал дутагдах, шамшигдах, нягтлан бодох бүртгэл, тайлагналын холбогдох хууль, стандартууд зөрчигдөх	<u>ҮАГ-ын зөвлөмж</u> -Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21 дүгээр заалтыг хэрэгжүүлж ажиллах. -Энэхүү зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэх. <u>Төсвийн захирагчийн хариу</u> Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.4 худалдан авалтын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Ашид нэхмэл ХХК-д ноосон даавууны үнэ 24.8 сая, Киокаут ХХК-д одонгийн хайрцагны үнэ 10.0 сая, АСЕМ-ын модон замын үнэнд 10.0 сая төгрөг зэрэг нийт 44.8 сая төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд худалдаж авсан нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

-Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлж худалдан авалтыг харьцуулалтын арга хэрэглэн гүйцэтгэж байх.

-Энэхүү зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/			
Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015.12.31	2016.12.31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		755,941.2	723,763.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	84,983.2	127,721.0
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	90,231.3	180,000.4
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	580,726.7	416,041.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		522,049.4	234,892.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	522,049.4	234,892.2
Биет хөрөнгө		518,970.8	234,892.2
Биет бус хөрөнгө	13	3,078.7	0.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,277,990.7	958,655.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР		697.1	11,748.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	697.1	11,748.1
Өглөг	17а, 17б	697.1	11,748.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,277,990.7	946,907.2
Засгийн газрын хувь оролцоо		1,277,990.7	946,907.2
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/		478,756.3	419,275.6
Хуримтлагдсан үр дүн		769,886.2	511,108.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		28,651.1	16,522.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,277,990.7	958,655.3

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015.12.31	2016.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		6,113,781.4	4,605,381.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	22,924.2	825,303.2
Нийтлэг татварын бус орлого		22,924.2	243,278.3
Тусламжийн орлого		0.0	582,024.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,090,857.2	3,780,078.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	6,054,677.4	4,816,921.2
УРСГАЛ ЗАРДАЛ		6,054,677.4	4,816,921.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,779,609.4	4,258,869.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,254,070.1	1,148,863.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		158,849.4	121,614.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		0.0	4,680.3
Хангамж, бараа материалын зардал		191,223.7	171,067.5
Нормативт зардал		1,179.7	2,184.8
Эд хогшил, урсгал засварын зардал		15,740.0	9,531.4
Томилолт, зочны зардал		2,550,968.3	1,145,296.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		430,057.2	358,471.7
Бараа үйлчилгээний бусад зардал		1,177,521.0	1,297,159.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		275,068.0	558,052.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		59,104.0	-211,539.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		59,104.0	-211,539.8

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	ЗГ-ын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр өмч хөрөнгө
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,274,741.8		1,274,741.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-173,377.4		-173,377.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,101,364.4		1,101,364.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	116,825.3		116,825.3
Тайлант үеийн үр дүн	59,104.0		59,104.0
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,277,293.6		1,277,293.6
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,277,293.6		1,277,293.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-27,451.6		-27,451.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,249,842.0		1,249,842.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-91,395.1		-91,395.1
Тайлант үеийн үр дүн	-211,539.8		-211,539.8
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	946,907.2		946,907.2

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,069,515.0	4,576,718.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,924.2	789,076.3
Нийтлэг татварын бус орлого	22,924.2	207,051.5
Тусламжийн орлого	0.0	582,024.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,046,590.8	3,787,641.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,958,280.1	4,533,980.4
УРСГАЛ ЗАРДАЛ	5,958,280.1	4,533,980.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,669,048.7	3,975,928.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,255,191.0	1,111,704.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,047.4	121,624.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	4,680.3
Хангамж, бараа материалын зардал	196,703.3	171,348.0
Нормативт зардал	1,179.7	2,184.8
Эд хогшил, урсгал засварын зардал	17,135.8	11,634.3
Томилолт, зочны зардал	2,533,130.0	1,269,268.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	452,468.6	376,167.7
Бараа үйлчилгээний бусад зардал	1,055,192.9	907,316.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	289,231.5	558,052.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	111,234.9	42,737.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	26,251.6	0.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,251.6	0.0
Дотоод эх үүсвэрээр	26,251.6	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-26,251.6	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	84,983.2	42,737.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	84,983.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,983.2	127,721.0

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,769,278.3	3,618,531.2	150,747.1	96.0
УРСГАЛ ЗАРДАЛ	3,769,278.3	3,618,531.2	150,747.1	96.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,571,281.4	3,420,566.4	150,715.0	95.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	936,841.5	936,841.5	0.0	100.0
Үндсэн цалин	895,887.8	895,887.8	0.0	100.0
Нэмэгдэл	0.00	0.00	0.0	0.00
Унаа хоолны хөнгөлөлт	40,953.7	40,953.7	0.0	100.0
Урамшуулал	0.00	0.00	0.0	0.0
Гэрээт ажлын хөлс	0.00	0.00	0.0	0.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,115.6	103,104.4	11.2	99.99
Тэтгэврийн даатгал	65,619.0	103,104.4	-37,485.4	157.13
Тэтгэмжийн даатгал	7,499.3	0.0	7,499.3	100.0
ҮОМШӨ-ний даатгал	9,374.1	0.0	9,374.1	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,874.9	0.0	1,874.9	100.0
Эрүүл мэндийн даатгал	18,748.3	0.0	18,748.3	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,672.0	3,672.0	0.0	100.0
Гэрэл, цахилгаан	0.0	0.0	0.0	0.0
Түлш, халаалт	0.0	0.0	0.0	0.0
Цэвэр, бохир ус	0.0	0.0	0.0	0.0
Байрны түрээс	3,672.0	3,672.0	0.0	100.0
Хангамж, бараа материалын зардал	168,185.1	168,117.3	67.8	100.0
Бичиг хэрэг	15,367.0	18,061.1	-2,694.1	117.5
Тээвэр, шатахуун	102,956.2	103,857.8	-901.6	100.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	49,253.1	45,960.5	3,292.6	93.31
Ном, хэвлэл	0.0	0.0	0.0	0.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	0.0	0.0	0.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	608.8	237.9	370.9	39.1
Нормативт зардал	5,000.0	2,184.8	2,815.2	43.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000.0	2,184.8	2,815.2	43.70
Хоол, хүнс	0.0	0.0	0.0	0.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	0.0	0.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	12,126.9	11,634.2	492.7	95.9
Багаж, техник, хэрэгсэл	5,151.4	5,567.0	-415.6	108.1

Тавилга	0.0	0.0	0.0	0.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0	0.0	0.0	0.0
Урсгал засвар	6,975.5	6,067.3	908.2	87.0
Томилолт, зочны зардал	1,272,521.5	1,125,385.7	147,135.8	88.4
Гадаад албан томилолт	1,037,788.5	890,789.0	146,999.5	85.8
Дотоод албан томилолт	57,160.0	43,647.0	13,513.0	76.4
Зочин төлөөлөгч хүлээн авах	177,573.0	190,949.6	-13,376.6	107.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,492.4	164,338.0	154.4	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	164,336.0	164,181.6	154.4	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	0.00	0.0	0.0
Даатгалын үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	0.0	0.0	0.0	0.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.0	0.0	0.0	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.0
Газрын төлбөр	0.0	0.0	0.0	0.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.0	0.0	0.0	0.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	156.4	156.4	0.0	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	905,326.4	905,288.5	37.9	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	882,789.1	882,751.2	37.9	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,537.3	22,537.3	0.0	100.0
ХҮҮ	0.0	0.0	0.0	0.0
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	0.0
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	0.0
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	0.0
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	0.0
ТАТААС	0.0	0.0	0.0	0.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.0	0.0	0.0	0.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.0	0.0	0.0	0.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.0	0.0	0.0	0.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.0	0.0	0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	197,996.9	197,964.8	32.1	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00	0.0	0.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00	0.0	0.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00	0.0	0.0
Бусад урсгал шилжүүлэг	197,996.9	197,964.8	32.1	100.0

Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	0.0	0.0	0.0	0.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	107,996.9	107,981.3	15.6	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,000.0	89,983.5	16.5	100.0
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	0.0	0.0	0.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	0.0	0.0	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0	0.0	0.0
Барилга байгууламж	0.0	0.0	0.0	0.0
Их засвар	0.0	0.0	0.0	0.0
Тоног төхөөрөмж	0.0	0.0	0.0	0.0
Бусад хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0
Стратегийн нөөц хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0	0.0	0.0
Эргэж төлөгдөх зээл	0.0	0.0	0.0	0.0
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	0.0	0.0	0.0	0.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	0.0	0.0	0.0	0.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,769,278.3	3,620,856.2	148,422.1	96.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,769,278.3	3,620,856.2	148,422.1	96.1
Улсын төсвөөс санхүүжих	3,769,278.3	3,620,856.2	148,422.1	96.1
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
Орон нутгийн төсвөөс	0.0	0.0	0.0	0.0
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.0	0.0	0.0	0.0

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
Хүний хөгжил сангийн төсвөөс санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.0	0.0	0.0	0.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	0.0	0.0	0.0	0.0
БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.0	0.0	0.0	0.0
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	0.0	0.0	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	2,325.0	-2,325.0	0.00
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	123.0	123.0	0.0	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.0	3.0	0.0	100.0
Төсвийн байгууллага	3.0	3.0	0.0	100.0
Төсвөөс гадуур байгууллага	0.0	0.0	0.0	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	60.0	60.0	0.0	100.0
Удирдах ажилтан	14.0	14.0	0.0	100.0
Гүйцэтгэх ажилтан	46.0	46.0	0.0	100.0
Үйлчлэх ажилтан	0.0	0.0	0.0	0.0
Гэрээт ажилтан	0.0	0.0	0.0	0.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	0.0	0.0	0.0	0.0
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	0.0	0.0	0.0	0.0
Төрийн өмчит ЕБС	0.0	0.0	0.0	0.0
Хувийн ЕБС	0.0	0.0	0.0	0.0
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	0.0	0.0	0.0	0.0
Төрийн өмчит СӨБ байгууллага	0.0	0.0	0.0	0.0
Хувийн өмчит СӨБ байгууллага	0.0	0.0	0.0	0.0
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0.0	0.0	0.0	0.0

Төрийн өмчит МСҮТ	0.0	0.0	0.0	0.0
Хувийн МСҮТ	0.0	0.0	0.0	0.0
ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0.0	0.0	0.0	0.0
Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	0.0	0.0	0.0	0.0
Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	0.0	0.0	0.0	0.0
Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо	0.0	0.0	0.0	0.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	60.0	60.0	0.0	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	51.0	51.0	0.0	100.0
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	0.0	0.0	0.0	0.0
Ажлын албаны албан хаагч (АА)	0.0	0.0	0.0	0.0
СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	0.0	0.0	0.0	0.0
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	3.0	3.0	0.0	100.0
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.0	1.0	0.0	100.0
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	0.0	0.0	0.0	0.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	0.0	0.0	0.0	0.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.0	4.0	0.0	100.0
Гэрээт ажилтан	0.0	0.0	0.0	0.0
Улс төрийн албан хаагч (УТ)	1.0	1.0	0.0	100.0